



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/699

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Алагтолгой багийн 1 дүгээр гудамжны 48 тоотод байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Пүрэвийн Болормаа /ПЮ73110304/-ийн эзэмшлийн 720.0 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Алтангэрэлийн Лхагвасүрэн /ПП87051308/-д хаягийг Баянбулаг 4 дүгээр гудамжны 412 тоот болгон 15 жилийн хугацаагаар шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/699 Ch  
02 03433